

Санхүүжүүлэгч



Funded by the
European Union

Удирдан гүйцэтгэгч



Хамтран хэрэгжүүлэгч



БҮГД ЗАЛУУСЫН ТӨЛӨӨ, ЗАЛУУС БҮГДИЙН ТӨЛӨӨ ТӨСӨЛ

Суурь судалгааны тайлан
/Жендэрийн мэдээлэл багтсан/

Улаанбаатар хот
2020 он



Энэхүү судалгаа нь Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй "Бүгд Залуусын Төлөө, Залуус бүгдийн төлөө" төслийн хүрээнд хийгдсэн болно. Тус судалгааны агуулга нь Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй болно.

АГУУЛГА

ТАЛАРХАЛ	6
СУДАЛГААНЫ БАГ	6
БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7
1.1 ТӨСЛИЙН ТУХАЙ	7
1.2 ҮНДЭСЛЭЛ	8
БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	10
2.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ	10
2.2 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ	10
2.3 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ	11
2.4 СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАЛТ	11
БҮЛЭГ 3. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ГАРААНЫ ТҮВШИН	12
3.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	12
3.2 ТББ-ЫН ЧАДАВХ /ТӨСЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ-1/	16
3.3 ТББ-ЫН ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА /ТӨСЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ-2/	25
3.4 ТББ-ЫН ЗАЛУУЧУУДЫН ИРГЭНИЙ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА /ТӨСЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ-3/	29
3.5 ЗАЛУУЧУУДЫН САЙН ДУРЫН АЖЛЫГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА /ТӨСЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ-4/	33
3.6 КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	36
3.7 ЗАЛУУЧУУДЫН БАЙГУУЛЛАГУУДАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА	38
БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	39
4.1 ДҮГНЭЛТ	39
4.2 ЗӨВЛӨМЖ	43
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	46
ХАВСРАЛТ 1. АСУУЛГА	46
ХАВСРАЛТ 2. УУЛЗАЛТЫН ХУВААРЬ	
ХАВСРАЛТ 3. СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ	

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1	ТББ-ын тоо	8
Зураг 2	Судалгаанд оролцогчдын иргэний нийгмийн төлөөлөл	12
Зураг 3	Судалгаанд оролцогчдын хүйс, байршлаар	13
Зураг 4	Судалгаанд хамрагдагсдын байршил	13
Зураг 5	ИНБ-ын үүсгэн байгуулагдсан он, байршлаар	14
Зураг 6	ИНБ-ын үйл ажиллагааны чиглэл	14
Зураг 7	ИНБ-ын үйл ажиллагааны төрөл	15
Зураг 8	ИНБ-ын салбар нэгж	18
Зураг 9	ИНБ-ын оффисын байрны төрөл	18
Зураг 10	ИНБ-ууд оффисын байртай эсэх, байршлаар	18
Зураг 11	ИНБ-ын үйл ажиллагааны хэвийн байдал	19
Зураг 12	ИНБ-уудын жилд хэрэгжүүлж буй төсөл, үйл ажиллагааны тоо	19
Зураг 13	ИНБ-уудын төлөвлөгөө, менежментийн байдал	20
Зураг 14	ИНБ-уудийн төрөөс явуулж буй бодлого, хууль, журмын талаарх мэдээлэл	21
Зураг 15	ТББ-уудад тулгарч буй хүндрэл бэрхшээл	22
Зураг 16	ТББ-ын ажилчдын ур чадварын үнэлгээ	23
Зураг 17	ИНБ-ын санхүүжилтын хэлбэр	24
Зураг 18	ИНБ-ын бусад байгууллагуудтай хамтран ажиллах чиглэл	24
Зураг 19	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төрөөс явуулж буй үйл ажиллагааны талаарх мэдлэг	28
Зураг 20	ИНБ-ын иргэний оролцооны чиглэлээр ажиллаж байсан туршлага	30
Зураг 21	ИНБ-ын төр засгийн байгууллагуудтай хамтран ажиллаж буй чиглэл	31
Зураг 22	ИНБ-ын төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлын үнэлгээ	31
Зураг 22a	ИНБ-уудын бодлого, хөтөлбөрийн талаарх мэдээлэл	32
Зураг 23	ИНБ-ын оролцооны байдал	32
Зураг 24	Иргэний оролцооны дэмжих чиглэлээр үйл ажиллагаа	33
Зураг 25	ИНБ-ууд сайн дурын ажлын хөтөлбөртэй эсэх, байршлаар	33
Зураг 26	Сайн дурын ажилчдаа жилд сургалтад хамруулдаг цаг	34
Зураг 27	Сайн дурын ажилчдын урамшууллын тогтолцоо	34
Зураг 28	ИНБ-уудын сайн дурын үйл ажиллагааны талаарх хууль, журмын талаарх мэдлэг	35
Зураг 29	Сайн дурын ажилчдыг үйл ажиллагаандаа оролцуулахад хангалттай мэдлэг бий эсэх	35
Зураг 30	Ковид-19 нөхцөл байдлын нөлөөлөл	36
Зураг 31	Ковид-19 нөхцөл байдалтай холбоотой бэрхшээл, боломжийг ашиглаж байгаа эсэх	37
Зураг 32	Тулгамдаж буй асуудал	38

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	ИНБ-уудын үйл ажиллагааны төрөл, байршлаар	16
Хүснэгт 2	Байгууллагын хүний нөөцийн бүтэц	17
Хүснэгт 3	Залуучуудын ажилгүйдлийн түвшин	25
Хүснэгт 4	Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа	26
Хүснэгт 5	Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжүүлэхэд тулгамдаж буй бэрхшээл	26
Хүснэгт 6	Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хамтран ажилладаг байгууллагууд	27
Хүснэгт 7	Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр бусад байгууллагуудтай хамтран ажиллахад тулгамддаг бэрхшээл	27
Хүснэгт 8	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, бизнесийг дэмжих нөөц, бололцоо	28
Хүснэгт 9	Залуучуудын иргэний оролцооны чиглэлээр явуулдаг үйл ажиллагаа	29

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АХБ	Азийн хөгжлийн банк
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ИБТ	Иргэний Боловсролын Төв
КЧР	Каритас Чех Репаблик
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
МЗЭ	Монголын Залуучуудын Эвсэл
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл

ТАЛАРХАЛ



ЯНА ЗИЛКОВА
КАРИТАС ЧЕХ РИПАБЛИК
БАЙГУУЛЛАГЫН СУУРИН
ТӨЛӨӨЛӨГЧ

Каритас Чех Репаблик, Иргэний Боловсролын Төв, Монголын Залуучуудын Эвсэл хамтран Европын Холбооны дэмжлэгтэйгээр “Бүгд залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө” төслийг хэрэгжүүлж байна.

Энэхүү төслийн хэрэгжилтийн хүрээнд залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын зураглал гаргах суурь судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны ажлыг зохион байгуулахад болон уулзалт, хурал, тоон судалгаанд хамрагдаж шаардлагатай мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан бүх төрийн бус байгууллага, иргэний нийгэм, залуучуудын эвсэл, бүлгэмийн төлөөллүүдэд талархал илэрхийлье.

СУДАЛГААНЫ БАГ

“Бүгд залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө” төслийн суурь шатны мэдээлэл цуглуулах судалгааны ажлыг дараах багийн бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэлээ.

Судалгааны тайлан
боловсруулсан:



Г.УУГАНЦЭЦЭГ
Мониторинг, үнэлгээний
хэлтсийн захирал,
Эс Ай Си Эй ХХК

Судалгааны зохион
байгуулалтад дэмжлэг үзүүлсэн:



Л.ДЭЛГЭРМАА
Төслийн Менежер,
Каритас Чех Репаблик



Д.ДАВААДУЛАМ
Туслах судлаач,
Нийгэм судлалын институтийн
дата лаборатори



Б.МӨНХТУЯА
Төслийн Туслах Ажилтан,
Каритас Чех Репаблик

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 ТӨСЛИЙН ТУХАЙ

Каритас Чех Репаблик нь Иргэний Боловсролын Төв, Монголын Залуучуудын Эвсэлтэй хамтран “Бүгд залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө” төслийг 2020-2023 оны хооронд Европын Холбооны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэхүү төсөл нь залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудыг дэмжих, чадавхыг бэхжүүлэх, залуучуудын байгууллагуудын сүлжээ үүсгэх, залуучуудын хөгжилд нөлөөлөл хийх замаар засаглал, шийдвэр гаргалт, төрийн бодлогын хэрэгжилтэд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, иргэний нийгмийг бэхжүүлэх үндсэн зорилготой юм.

Тус зорилгыг биелүүлж ажиллахын тулд төсөл нь дараах 4 үндсэн чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэх юм. Үүнд:

- I Залуучуудын чиглэлээр ажилладаг ТББ-уудыг чадавхжуулах
- II Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
- III Залуучуудын иргэний оролцоог нэмэгдүүлэх
- IV Залуучуудыг сайн дурын ажилд оролцуулах

Нэгдүгээр зорилтын хүрээнд, залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын зураглал хийх, залуучуудын иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ бий болгох, иргэний нийгэм, төрийн бус байгууллагуудыг сургалтад хамруулах, сургагч багш бэлтгэх, Европын болон дотоодод аймаг хооронд сайн туршлага судлах, солилцох үйл ажиллагааг зохион байгуулах ажлыг төлөвлөсөн.

Хоёрдугаар зорилтын хүрээнд, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгуулах, менторшип буюу зөвлөн дагуулах хөтөлбөр хэрэгжүүлэх, залуучуудын гарааны бизнесийн төслийн уралдаан зарлах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад ажлууд болох хакатон, хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг, санхүүжилт босгох үйл ажиллагаа, аппликейшн хөгжүүлэх зэрэг ажлуудыг төлөвлөж, хэрэгжүүлж эхлүүлээд байна.


Гуравдугаар зорилтын хүрээнд, залуучуудын оролцооны бодит, амжилттай түүхүүдийг хуваалцах, иргэний оролцооны сайн туршлагыг түгээх, төрийн байгууллагуудтай залуучуудын хамтын ажиллагааг дэмжсэн семинар зохион байгуулах, залуучуудын утга учиртай оролцоог дэмжих талаар, залуучуудын асуудлаар бодлого боловсруулах чиглэлээр төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, залуучуудын сонгуулийн идэвх оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд залуучуудын сайн дурын ажлыг дэмжих, сайн дурын ажилтнуудын нэгдсэн платформ хөгжүүлэх, сайн дурын ажлын талаар зөв ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах юм.

1.2 ҮНДЭСЛЭЛ

1990 оноос өмнө Монгол Улсын Засгийн газар социалист дэглэмийн хүрээнд Иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-уудыг олон нийтийн байгууллага гэж нэрлэж, ажиллуулж байсан. Үүнд, Үйлдвэрчний эвлэл, Монголын залуучуудын холбоо, Монголын эмэгтэйчүүдийн холбоо зэрэг олны танил жишээг дурдаж болно¹. 1992 онд Монгол улс шинэ ардчилсан Үндсэн хууль баталж засгийн бүх эрх ард түмний мэдэлд байж, хүний эрх, эрх чөлөөг хуульчлан баталгаажуулсан нь оролцооны үндсэн эрхүүд хэрэгжих эхлэл болсон юм. Монгол улсын иргэд шууд болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан төрийг удирдах эрхтэй болж, үзэл бодлоо янз бүрийн түвшинд илэрхийлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаанд оролцох, гэр бүл нийгмийн харилцаанд эрэгтэй эмэгтэй хүмүүс тэгш оролцох зэрэг эрхүүд хууль тогтоомжуудад тусгагдсан байна². Тухайлбал Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 10-т “Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс олон нийтийн байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэж эвлэлдэн нэгдэх, сайн дурын байгууллага байгуулах эрхийг баталгаажуулж өгсөн. Энэхүү эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулж ТББ-ын эрх зүйн байдлыг зохицуулах үүднээс 1997 онд “Төрийн бус байгууллагын тухай хууль”-ийг батлан гаргасан³.

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны бизнес регистрийн сангийн бүртгэлийн 2019 оны мэдээгээр Монгол Улсад бүртгэлтэй нийт 22,4 мянган төрийн бус байгууллага байгаагаас үйл ажиллагаа явуулж буй 10,7 мянган төрийн бус байгууллага ажиллаж байна. ТББ-ын тухай хууль хэрэгжиж ирснээс хойш Монгол Улсад төрийн бус байгууллагуудын тоо нэмэгдэж, цар хүрээ, үйл ажиллагааны чиглэл, салбарын хувьд өргөжин тэлсэн байна. Тухайлбал, 1998 онд 1,075 ТББ бүртгэлтэйгээс 1,072 нь үйл ажиллагаа явуулдаг гэсэн бол 2019 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй ТББ-ын тоо 10 дахин өссөн байна.



Зураг 1: ТББ-ын тоо

¹ АХБ (2019). Иргэний нийгмийн танилцуулга: Монгол Улс

² Улс төрийн боловсролын академи (2013). Иргэдийн оролцооны эрх зүйн орчин ба үнэлгээ судалгааны тайлан. х-12

³ Хууль зүйн үндэсний хүрээлэн (2013). Төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.

Хэдийгээр бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын тоо, ТББ-ын төрлийн мэдээ албан ёсны захиргааны статистикт байгаа боловч үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын чадавх, үйл ажиллагааны чиглэл, идэвх, оролцооны талаар нэгдсэн суурь мэдээлэл, судалгаа, статистик байхгүй байна. Иргэний нийгэм, ТББ-ууд үйл ажиллагаа явуулж буй салбар бүртээ харилцан адилгүй хөгжиж байгаа нь тухайн салбарын талаарх төрийн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаатай салшгүй холбоотой юм.

Залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллага, ТББ-уудын мөн адил нэгдсэн суурь мэдээлэл байхгүй хэдий ч, сүүлийн жилүүдэд залуучуудын хөгжил, оролцоог нэмэгдүүлэх хүрээнд төрөл бүрийн залуучуудын санаачилга, бүлгэм, ТББ-ууд үүсэж, хөгжиж байна. Учир нь Монгол Улсын хүн амын 63% нь 35 хүртэлх насны хүүхэд, залуучууд бөгөөд хөдөлмөрийн насны хүн ам буюу 25-34 насны залуучууд хамгийн их хувийг эзэлж байна. Нийт хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь өндөр байх үеийг “Хүн ам зүйн цонх” гэдэг. Хүн ам зүйн цонх нээгдсэн үед хүүхэд, залуучуудын боловсролын түвшнийг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх урт хугацааны бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэн, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байрыг нэмэгдүүлсэн нөхцөлд ажиллах хүчний нөөц хүрэлцэхүйц байх нөхцөл бүрдсэн гэж ойлгож болох юм⁴. Гэвч залуучууд нийт ажилгүй хүн амын талаас илүү буюу 56.1%-ийг эзэлж байна. Иймээс “Бүгд залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө” төслийн үйл ажиллагаа нь залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах, хамтын ажиллагааны нэгдсэн сүлжээ бий болгох, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэргээр ажиллах гэж буй нь цагаа олсон, ач холбогдолтой юм. Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд өнөөгийн нөхцөл байдлыг зураглах, гарааны түвшнийг тодорхойлох шаардлага үүсэж бий болсон.



⁴ УСХ (2019). Монгол Улсын хүн амын салбар

БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү суурь судалгааны зорилго нь залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй залуучууд, иргэний нийгмийн байгууллагуудын чадавх, тулгамдаж буй асуудлуудыг судлах замаар төслийн 4 үндсэн чиглэлийн хүрээнд гарааны үзүүлэлтүүдийг тодорхойлох, ТББ-уудын зураглал хийхэд оршино.

Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд төслийн дараах 4 үндсэн чиглэлийн дагуу болон шинэ төрлийн вирус КОВИД-19 цар тахлын үеийн өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах:

Үндсэн чиглэл 1: Төрийн бус байгууллагын чадавхыг бэхжүүлэх

Үндсэн чиглэл 2: Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Үндсэн чиглэл 3: Залуучуудын иргэний оролцоог нэмэгдүүлэх

Үндсэн чиглэл 4: Залуучуудыг сайн дурын ажилд оролцуулах

КОВИД-19 нөлөө

2.2 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

Төрийн бус байгууллагуудын зураглал хийх энэхүү суурь судалгааны хүрээнд тоон болон чанарын дараах аргуудыг ашиглаж, мэдээлэл цуглуулалтыг хийж гүйцэтгэлээ.

2.2.1 Баримт бичгийн судалгаа

Залуучуудын талаарх холбогдох статистик мэдээлэл, ижил төстэй бусад судалгааны тайлангуудыг судалгааны асуулга, асуултууд боловсруулахдаа болон тайлан бичих явцдаа хоёрдогч мэдээлэл болгон ашигласан.

2.2.2 Чанарын судалгаа

Төслийн багаас зохион байгуулсан иргэний нийгмийн төлөөллүүдэд төслөө танилцуулах уулзалт, ярилцлагад хамтран оролцож төрийн бус байгууллагуудын ерөнхий танилцуулга, өнөөгийн нөхцөл байдалтай холбогдолтой мэдээлэл болон тулгамдаж буй асуудлын талаарх мэдээллүүд цуглуулсан. Суурь судалгаанд ашигласан чанарын мэдээллийг 5 удаагийн цахим уулзалт, 5 удаагийн биечлэн зохион байгуулагдсан уулзалтын хүрээнд цуглуулсан.

2.2.3 Тоон судалгаа

Төрийн бус байгууллага, иргэний нийгэм, залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бүлгэмүүдээс судалгааны үндсэн мэдээллийг тоон буюу асуулга судалгааны аргаар цуглуулсан. Асуулгыг цахимд суурилсан буюу CAWI (computer assisted web interviewing) аргаар болон цаасаар цуглуулсан. Судалгаанд нийт 124 оролцогч хамрагдсан.

Судалгааны анкетыг төслийн үндсэн 4 зорилтын хүрээнд гарааны нөхцөл байдлыг тодорхойлох, асуудал шийдлийг тодорхойлох зорилгоор боловсруулсан. Ингэснээр олон талын байр суурь, санал бодол, мэдээллүүдийг нэгтгэн дүгнэх бололцоотой болох ба судалгааны үр дүн илүү бодитой гарах болно.

Мөн түүнчлэн анкетын аргаар судалгааны мэдээллийг цуглуулахдаа төслийн багаас зохион байгуулсан иргэний нийгмийн төлөөллүүдэд төслөө танилцуулах онлайн болон орон нутаг дахь уулзалтуудын дараа судалгааны санал асуулгыг бөглүүлсэн бөгөөд энэ нь судалгаанд оролцогчид төслийн зорилго, үнэт зүйлийг таньж мэдсэний үндсэн дээр асуумжид хариулж, өөрсдийн тулгамдаж буй асуудал, шийдлийн талаар чөлөөтэй хуваалцах, чанартай мэдээлэл цуглуулах боломжийг олгож байгаа явдал юм.

2.3 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү судалгаа нь төслийн зорилтот аймгууд болох Хэнтий, Сэлэнгэ, Дорноговь, Баянхонгор болон Улаанбаатар хотыг хамарсан.

2.4 СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАЛТ

Судалгааг гүйцэтгэх явцад дараах хүчин зүйлсийн улмаас ажлын хүрээ хязгаарлагдаж байв. Үүнд:

1. КОВИД-19 цар тахлын хөл хориотой холбоотойгоор судалгааны мэдээлэл цуглуулалт зарим талаар хязгаарлагдмал хүрээнд хийгдсэн. Шинэ төрлийн вирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой Комиссоос авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд зарим байгууллагуудын үйл ажиллагаа зогсонги, гишүүд, ажилчид түр хугацаагаар идэвхгүй байсантай холбоотойгоор судалгаанд хамрагдаж мэдээлэл өгсөн байгууллагуудын тоо хязгаарлагдмал байсан.


2. Энэхүү судалгаа нь “Бүгд залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө” төслийн суурь судалгааны хүрээнд хийгдсэн тул Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх төрийн бус байгууллагуудыг хамруулаагүй, судалгааны үр дүн, мэдээлэл нь Монгол Улсын иргэний нийгмийн байгууллагын дүр зургийг бүрэн илэрхийлэхгүй, зөвхөн төслийн үйл ажиллагаанд оролцох сонирхолтой байгаа судалгаанд хамрагдсан байгууллагуудын ерөнхий зураглалыг харуулсан болно. Мөн түүнчлэн энэхүү судалгаа нь иргэний нийгмийн байгууллагын хүний нөөцийн ур чадварын үнэлгээ биш, зөвхөн судалгаанд хамрагдсан байгууллагуудын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж буй явдал юм.

БҮЛЭГ 3. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ГАРААНЫ ТҮВШИН

3.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэ хэсэгт судалгаанд хамрагдсан залуучуудын хөгжил, оролцооны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн төлөөлөл болсон төрийн бус байгууллага, эвсэл, холбоо, бүлэг, клубүүд болон залуучуудын ерөнхий мэдээллийг орууллаа.


“Бүгд залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө” төслийн суурь судалгаанд иргэний нийгмийн төлөөлөл болсон нийт 124 оролцогч хамрагдсан бөгөөд судалгаанд оролцогчдыг аль иргэний нийгмийн хэлбэрийг төлөөлж байгаагаар нь авч үзвэл:



Зураг 2 Судалгаанд оролцогчдын иргэний нийгмийн төлөөлөл


Үүнээс үзэхэд 5.6 хувь нь эвсэл, холбоо, 9.7 хувь нь бүлэг, клуб, 34.7 хувь нь төрийн бус байгууллага, 50 хувь нь бусад иргэний нийгмийн төлөөллүүд байна. Эдгээр бусад иргэний нийгмийн төлөөлөлд залуучууд, орон нутгийн залуучууд хөгжлийн төвийн мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагын ажилтан гишүүд, хүүхэд залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төвүүд хамрагдаж өөрсдийн тулгамдсан асуудал, төслийн талаарх санал шийдлээ хуваалцан судалгаанд оролцсон байна. Харин судалгаанд оролцогч нийт төрийн бус байгууллагын төрлийн хувьд 90 хувь нь нийгэмд үйлчилдэг үлдсэн 10 хувь нь гишүүдээ үйлчилдэг төрийн бус байгууллага байна.

Нийт судалгаанд оролцогчдын 43 хувь нь эрэгтэй бол 57 хувь нь эмэгтэй байна. Төслийн зорилтод 5 байршлаар судалгаанд оролцогчдын хүйсийг харьцуулан харвал Улаанбаатар хот, Дорноговь аймагт дийлэнх хувь нь эмэгтэйчүүд байгаа бол Сэлэнгэ, Баянхонгор аймгуудад хүйсийн харьцаа харьцангуй тэнцүү Хэнтий аймагт ихэнх хувь нь буюу 56.0 хувь эрэгтэйчүүд байна.




Зураг 3 Судалгаанд оролцогчдын хүйс, байршлаар

Байршлын хувьд авч үзвэл “Бүгд залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө” төслийн зорилтот 4 аймаг болох Хэнтий, Сэлэнгэ, Дорноговь, Баянхонгор болон Улаанбаатар хотын иргэний нийгмийн төлөөллүүд хамрагдсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 20.3 хувь нь Улаанбаатар хот, 22.0 хувь нь Дорноговь, Сэлэнгэ аймаг тус бүр 22.0 хувь, Хэнтий аймаг 21.1 хувь бол Баянхонгор аймаг 14.6 хувьтай байна.



Зураг 4 Судалгаанд хамрагдагсдын байршил

Судалгаанд оролцсон иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаагаа эхлүүлж үүсгэн байгуулагдсан оны хувьд харвал 7 хувь нь 1920-1990 он, 14 хувь нь 1991-2010 он, 79 хувь буюу дийлэнх хувь нь 2011-2020 онд үүсгэн байгуулагдсан байна. ИНБ-уудын үүсгэн байгуулагдсан оныг төслийн зорилтод таван байршлаар авч үзвэл Улаанбаатар хотын хувьд байгуулагдаад олон жил болсон болон шинээр үйл ажиллагаагаа эхлүүлж ажиллаж байгаа байгууллагуудын хувьд холимог шинжтэй байгаа бол зорилтод аймгуудын тухайд дийлэнх олонх хувь нь 2011 оноос хойш байгуулагдсан байна тухайлбал Баянхонгор аймгийн хувьд 100 хувь 2011 оноос хойш үйл ажиллагаа явуулж эхэлж байгаа иргэний нийгмийн төлөөллүүд оролцжээ.



Зураг 5 ИНБ-уудын үүсгэн байгуулагдсан он, байршлаар

Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл болон төрлийг харвал дараах байдалтай байна.



Зураг 6 ИНБ-уудын үйл ажиллагааны чиглэл

Иргэний нийгмийн байгууллагуудын хамгийн өндөр үзүүлэлттэй үйл ажиллагааны чиглэлүүдэд залуучуудын хөгжил оролцоо манлайлал, залуучуудын боловсрол, залуучуудын сайн дурын ажил, залуучуудын иргэний оролцоо болон улс төрийн боловсрол, залуучуудын хөдөлмөр бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлүүд байна. Үүнээс үзэхэд төслийн үндсэн зорилт, үйл ажиллагааны чиглэл болох залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэний оролцоог нэмэгдүүлэх, залуучуудын сайн дурын ажлыг дэмжих чиглэлээр дийлэнх ТББ үйл ажиллагаа явуулдаг болох нь харагдаж байна. Харин залуу гэр бүлийг дэмжих, гэр бүлийн боловсрол олгох,

эрсдэлт бүлгийн залуучуудын эрх ашгийг хамгаалах, БЗДХВ, ХДХВ, ДОХ-с урьдчилан сэргийлэх зэрэг тухайлсан асуудлууд дээр үйл ажиллагаа эрхэлдэг ТББ-ууд доогуур хувийг эзэлж байна.

Иргэний нийгмийн байгууллагууд нь үйл ажиллагааныхаа чиглэлээр дараах төрлийн үйл ажиллагаануудыг явуулдаг байна.



Зураг 7 ИНБ-уудын үйл ажиллагааны төрөл

Графикаас харвал иргэний нийгмийн байгууллагуудын хамгийн их хэрэгжүүлдэг үйл ажиллагааны төрөл нь залуучуудад чиглэсэн сургалт, залуучуудыг оролцуулсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон төрийн бодлого, шийдвэрт нөлөөлөх ажлууд байгаа бол залуучуудад чиглэсэн контент хийх, залуучуудад чиглэсэн ментор хөтөлбөр хамгийн бага хувийг эзэлж байна.

Үйл ажиллагааны төрлийг төслийн зорилтот байршилтай харьцуулан харвал Улаанбаатар хотын ИНБ-ууд бусад аймгуудтай харьцуулахад үйл ажиллагааны бүх төрлийн хувьд илүү идэвхтэй байдаг нь харагдаж байна. Баянхонгор аймгийн ИНБ-уудын хувьд залуучуудад чиглэсэн сургалт явуулдаг гэсэн хариулт хамгийн өндөр буюу 71.4 хувьтай, Дорноговь аймгийн ИНБ-уудын хувьд 70.8 хувь нь сургалт явуулдаг гэсэн бол тус аймгийн хувьд ментор хөтөлбөр, төрийн бодлого шийдвэрт нөлөөлөх үйл ажиллагааны төрлөөр бусад аймгуудаас хамгийн доогуур хувьтай нь байна. Сэлэнгэ аймгийн тухайд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, контент хийх үйл ажиллагааны төрөл бусад үйл ажиллагааны төрлүүдээс өндөр үзүүлэлттэй, Хэнтий аймгийн хувьд төрийн бодлого шийдвэрт нөлөөлөх болон сургалт явуулдаг гэсэн үйл ажиллагааны төрөл өндөр байгаа байгаа бол төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, контент хийх, ментор хөтөлбөр зэрэг үйл ажиллагаа дутмаг байна.

Зорилтот байршил	Үйл ажиллагааны төрөл	Сургалт явуулдаг	Төсөл, хөтөлбөр, хэрэгжүүлдэг	Контент хийдэг /подкаст, блог, постер, нийтлэл гм/	Ментор хөтөлбөр хийдэг	Залуучуудад чиглэсэн контент	Төрийн бодлого, шийдвэрт нөлөөлөх
Улаанбаатар хот		76.9%	88.5%	46.2%	34.6%	30.8%	53.8%
Баянхонгор аймаг		71.4%	42.9%	35.7%	14.3%	28.6%	35.7%
Дорноговь аймаг		70.8%	20.8%	20.8%	8.3%	8.3%	29.2%
Сэлэнгэ аймаг		50%	55%	55%	10%	20%	35%
Хэнтий аймаг		44%	0%	0%	0%	11.1%	44.4%

Хүснэгт 1 ИНБ-уудын үйл ажиллагааны төрөл, байршлаар

Иргэний нийгмийн байгууллагууд байгууллагын хэтийн зорилгоо бичнэ үү? гэсэн асуултад дараах ерөнхий 3 санаа бүхий хэтийн зорилгыг тодорхойлжээ.

1. ИНБ-ууд өөр өөрсдийн үйл ажиллагаа явуулдаг чиглэлээр залуучуудын хөгжил, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, залуучуудыг чадавхжуулах, сайн дурын ажилд оролцуулах, залуучуудын дуу хоолойг нийгэмд болон төрд хүргэх, тэдний эрх ашгийг хамгаалах, залуучуудад тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах.
2. Өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээр чадварлаг, тогтвортой, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг ИНБ болох.
3. Залуучуудын оролцоо, хөгжлийг дэмжих замаар сум, орон нутаг, улсынхаа хөгжилд хувь нэмэр оруулах гэсэн зорилгуудыг дэвшүүлсэн байна.

3.2 ТББ-ЫН ЧАДАВХ /ТӨСЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ-1/

Энэ хэсэгт иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг тодорхойлох зорилгоор төрийн бус байгууллагуудын салбар нэгж, үйл ажиллагааны тогтмол байдал, жилд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн тоо, байгууллагын төлөвлөгөө, тулгарч буй бэрхшээл, ажилчдын ур чадвар, санхүүгийн эх үүсвэр болон уг төсөлд хамрагдах, хамтран ажиллах хүсэлтэй байгаа эсэх талаар судалгааны мэдээллийн үр дүнг үзүүлж байна.

Судалгаанд хамрагдсан байгууллагын ажилчдын бүтэц, жендэрийн харьцааг авч үзвэл дараах байдалтай байна.


АНГИЛАЛ	ТОО	ХУВЬ/%/	
УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН			
1-5 удирдах албан тушаалтантай	53	79.1	Нийт 248 удирдах ажилтан байгаагаас 124 нь буюу 50 хувь нь эмэгтэй байна.
6-10 удирдах албан тушаалтантай	11	16.4	
11 болон түүнээс дээш удирдах албан тушаалтантай	3	4.5	
ҮНДСЭН АЖИЛТАН			
1-10 ажилтантай	38	74.5	Нийт 583 ажилтан байгаас 370 буюу 64 хувь нь эмэгтэйчүүд байна
11-20 ажилтантай	8	15.7	
21 болон түүнээс дээш ажилтантай	5	9.8	
САЙН ДУРЫН АЖИЛТАН			
1-20 сайн дурын ажилтантай	33	76.7	Нийт 2306 сайн дурын ажилтан байгаагаас 1370 буюу 59.4 хувь нь эмэгтэйчүүд байна
21-40 сайн дурын ажилтантай	2	4.7	
41-60 сайн дурын ажилтантай	1	2.3	
61 болон түүнээс дээш сайн дурын ажилтантай	7	16.3	
ГИШҮҮД			
1-50	25	53.2	Нийт 180,104 гишүүд байгаагаас 102452 буюу 57 хувь нь эмэгтэйчүүд байна
51-100 гишүүнтэй	5	10.6	
101-150 гишүүнтэй	3	6.4	
151-200 гишүүнтэй	1	2.1	
201-250 гишүүнтэй	2	4.3	
251 болон түүнээс дээш гишүүнтэй	11	23.4	

Хүснэгт 2 Байгууллагын хүний нөөцийн бүтэц

Үүнээс ТББ-ын 79.1 хувь нь 1-5 удирдах ажилтантай байна, үндсэн ажилтны хувьд 1-20 ажилтантай байгууллага дийлэнх хувийг эзэлж байгаа бол сайн дурын ажилтнуудыг хувьд 76.7 хувь нь 1-20 сайн дурын ажилтантай, 16.3 хувь нь 61 болон түүнээс дээш сайн дурын ажилтантай байна. Харин ИНБ-уудын гишүүдийн хувьд 53.2 хувь нь 1-50 гишүүнтэй байна.

Жендэрийн хувьд ИНБ-уудын удирдах албан тушаалтны 50 хувь нь эмэгтэй байгаа бол бусад үндсэн ажилчид, сайн дурын ажилтан, гишүүдийн хувьд ихэнх хувийг буюу 51 дээш хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Үүнээс харахад иргэний нийгмийн үйл ажиллагаанд эмэгтэй хүмүүс илүү зонхилох хандлагатай байна.


Иргэний нийгмийн байгууллагуудын салбар нэгжийн хувьд 40.3 хувь нь салбар нэгж байхгүй бол 38.8 хувь нь 1-3 салбартай, 7.5 хувь нь 4-10 салбартай бол үлдсэн 13.4 хувь нь 11 болон түүнээс дээш салбартай байгууллагууд байна.



Зураг 8 ИНБ-уудын салбар нэгж


Иргэний нийгмийн байгууллагуудын хувьд үйл ажиллагаа явуулдаг оффистой юу хэрэв оффистой бол оффисын байрны төрлийг тодруулахад нийт судалгаанд оролцогчдын 64.7 хувь нь үйл ажиллагаа явуулдаг оффистой, 35.3 хувь нь оффис байхгүй гэж хариулсан байна.

Үйл ажиллагаа явуулдаг оффистой байгууллагуудын хувьд ихэнх хувь нь буюу 56.5 хувь нь оффис түрээсэд, 23.9 хувь нь өөрийн байртай, 13.0 хувь нь бусад гэж хариулсан бөгөөд үүнд төслийн байр болон төрийн байгууллагаас олгож өгсөн байр багтаж байгаа бол хамгийн бага хувь нь буюу 6.5 хувь нь дундын оффистой байна.



Зураг 9 ИНБ-уудын оффисын байрны төрөл


ИНБ-уудыг оффисын байртай эсэхийг Улаанбаатар хот болон аймгуудаар харвал Улаанбаатар хот болон Хэнтий аймгийн оролцогчдын дийлэнх хувь нь байртай гэж хариулсан байна.



Зураг 10 ИНБ-ууд оффисын байртай эсэх, байршлаар


Дорноговь аймгийн иргэний нийгмийн төлөөллүүдийн ихэнх хувь нь буюу 60.0 хувь нь үйл ажиллагаа явуулдаг байр байхгүй гэжээ. Үүнээс үзэхэд Дорноговь болон Баянхонгор аймгийн ИНБ-уудын хувьд үйл ажиллагаа явуулах байр орон сууцны хувьд бусад байршлуудаас дутагдалтай байдаг байна.

Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны тогтмол байдал болон жилд хэрэгжүүлдэг төсөл, үйл ажиллагааны талаар тодруулахад иргэний нийгмийн байгууллагуудын ихэнх хувь нь буюу 56.5 хувь нь үйл ажиллагаа тогтмол гэсэн бол 27.5 хувь нь сардаа 1-3 удаа уулзалт үйл ажиллагаа зохион байгуулдаг, 13.0 хувь нь улиралд нэг удаа, 2.9 хувь хагас жилд 1 удаа болон түүнээс цөөн удаа уулзалт үйл ажиллагаа зохиодог гэжээ.



Зураг 11 ИНБ-уудын үйл ажиллагааны хэвийн байдал

Харин иргэний нийгмийн байгууллагуудын жилд хэрэгжүүлж буй төсөл, үйл ажиллагааны хувьд тал хувь нь буюу 52.2 хувь нь жилд 1-5 төсөл, үйл ажиллагаа хэрэгжүүлдэг, 9.0 хувь нь 6-10 төсөл, үйл ажиллагаа хэрэгжүүлдэг бол 10.5 хувь нь 11 болон түүнээс олон төсөл, үйл ажиллагаа хэрэгжүүлдэг, 28.4 хувь жил бүр төсөл үйл ажиллагаа хэрэгжүүлж чаддаггүй байна.




Зураг 12 ИНБ-уудын жилд хэрэгжүүлж буй төсөл, үйл ажиллагааны тоо

Судалгаанд хамрагдсан төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны тогтмол байдал болон хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн тоог авч үзвэл байгууллагуудын тал хувь нь үйл ажиллагаа тогтмол явуулдаг бөгөөд жилд тогтмол 1-5 төсөл

хэрэгжүүлдэг байгаа бол үлдсэн тал хувь нь сард болон улиралдаа уулзалт үйл ажиллагаа хийдэг, байгууллагуудын 20 орчим хувь нь 6-аас дээш төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг 30 орчим хувь нь жил бүр төсөл, үйл ажиллагаа хэрэгжүүлж чаддаггүй байна.

Харин залуучуудын чиглэлээр хэрэгжүүлж буй аливаа санаачилга, үйл ажиллагаандаа жендэрийн эрх тэгш байдлыг хангах тал дээр анхаарч ажилладаг уу? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын тал хувь нь буюу 50.7 хувь нь байнга анхаардаг, 31.3 хувь нь ихэнхдээ анхаардаг, 9.0 хувь нь заримдаа, 3.0 хувь нь хааяа, 6.0 хувь нь огт үгүй гэж хариулжээ. Үүнээс үзэхэд байгууллагууд аливаа санаачилга, үйл ажиллагаандаа дийлэнх хувь буюу 82 хувь нь энэ тал дээр байнга болон ихэнхдээ анхаардаг гэж үзсэн байна.

Иргэний нийгмийн байгууллагуудын жилийн болон урт богино хугацааны стратеги, эрсдэлийн менежмент төлөвлөгөө байгаа эсэх талаар авч үзвэл:




Зураг 13 ИНБ-уудын төлөвлөгөө, менежментийн байдал

Судалгаанд оролцогчдын 92.6 хувь нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөтэй, 74.6 хувь нь урт эсвэл богино хугацааны стратеги төлөвлөгөөтэй байгаа бол эрсдэлийн менежмент төлөвлөгөөний хувьд 60.9 нь байхгүй, 13.0 хувь нь мэдэхгүй байна.

Танай байгууллага явуулж буй үйл ажиллагаанд хамаарах төрийн бодлого, хууль, журам, шийдвэр, авч буй арга хэмжээ зэргийг мэдэх үү? гэсэн асуултад 37.7 хувь нь маш сайн мэднэ, үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг гэсэн бол 29.0 хувь нь мэдэх хэдий ч үйл ажиллагаандаа хэрэгжүүлж чаддаггүй бол 33.2 хувь нь сайн мэдэхгүй, огт мэдэхгүй гэсэн хариултуудыг өгчээ. Үүнээс харахад өөрсдийн явуулж буй үйл ажиллагаатай холбогдох хууль, журам бодлого шийдвэрийг мэдэх хэрэгжүүлэх байдал судалгаанд оролцогчдын 60 орчим хувьд ямар нэгэн байдлаар дутмаг байдаг нь ажиглагдсан.

Харин уг асуудлыг Улаанбаатар болон аймгуудаар харьцуулан авч үзэхэд Улаанбаатар хотын хувьд хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хамаарах төрийн бодлого, хууль, журам, шийдвэр, авч буй арга хэмжээ зэргийг мэдэх хэдий ч тэр бүр үйл ажиллагаандаа бодитоор хэрэгжүүлж чаддаггүй, Баянхонгор аймгийн төрийн бус байгууллагуудын хувьд бусад зорилтот таван байршлуудаас төрийн бодлого, хууль, журам, шийдвэр, авч буй арга хэмжээний хамгийн бага буюу нийт оролцогчдын ердөө 9.1 хувь нь энэ талаар маш сайн мэднэ хэрэгжүүлж ажилладаг гэсэн бол Дорноговь аймгийн хувьд 50.0 хувь энэ талаар маш сайн мэднэ гэж үзээд сайн мэдэхгүй, огт мэдэхгүй гэсэн хариултуудыг өгсөн оролцогч байхгүй байна.



Зураг 14 ИНБ-уудийн төрөөс явуулж буй бодлого, хууль, журмыг талаарх мэдээлэл

Иргэний нийгмийн байгууллагуудаас ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг бусад ТББ-уудтай хамтран ажилладаг эсэхийг тодруулахад судалгаанд хамрагдагчдын 73.5 хувь нь тийм, 26.5 хувь нь үгүй гэж хариулжээ. Харин 38.2 хувь нь төрийн бус байгууллагуудын сүлжээ, эвсэлд харьяалагддаг гэсэн бол үлдсэн 61.8 хувь нь ТББ-уудын ямар нэгэн сүлжээ/эвсэлд харьяалагддаггүй гэжээ.

Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа явуулахад хамгийн их тулгардаг бэрхшээлийг тодруулахад дийлэнх байгууллагад буюу 82.1 хувьд нь төсөв санхүүгийн асуудал хамгийн ихээр тулгардаг гэж үзсэн бол үүний дараагаар төрийн дэмжлэг хамтын ажиллагаа муу, гишүүдийн идэвх сул, үйл ажиллагаа явуулах байр орон сууц олддоггүй, олон улсын нийгэмлэгүүдтэй хамтын ажиллагаа муу, үйл ажиллагаа явуулахад хангалттай ур чадвар ажилчдад байдаггүй гэсэн хариултуудыг өгчээ.



Зураг 15 Төрийн бус байгууллагуудад тулгарч буй хүндрэл бэрхшээл

Тоон судалгаанаас гадна чанарын судалгаагаар илэрсэн ИНБ-уудад тулгамдаж буй зарим асуудлыг авч үзвэл



...Хөдөө орон нутгийн залуучуудад тулгамддаг бас нэгэн асуудал бол мэдээ мэдээлэл хомс байдаг явдал юм. Ялангуяа алслагдмал сумын залуучууд мэдээллээс маш их хоцордог. Иймээс мэдээллийг жигд хүргэх хэрэгтэй. Мэдээллээс хоцорсноос болоод дараа нь олон асуудал үүсдэг...

Хэнтий аймгийн ИНБ-уудтай хийсэн төслийн уулзалтын ярилцлагаас

...Төсөв санхүүгийн асуудал маш их тулгардаг, бид бүхэн өөрсдөө асуудлаа олж хараад шийдвэрлэх ажил хийе гэсэн санаа сэдэл маш их байдаг ч түүнийг зохион байгуулах төсөв мөнгө байхгүй, төсөв санхүүжилт хэрхэн олохоо мэддэггүй...

Хэнтий аймгийн ИНБ-уудтай хийсэн төслийн уулзалтын ярилцлагаас



...Ер нь хаа ч ямар ч үйл ажиллагаанд залуучуудын идэвх оролцоо муу байдаг, тэгээд бид бүхэн үйл ажиллагаа зохион байгуулаад залуучуудаа хамруулья гэхээр хэрхэн идэвхжүүлэх, оролцуулах, идэвхтэй хамруулах арга олдоггүй тохиолдол бий...

Сэлэнгэ аймгийн ИНБ-уудтай хийсэн төслийн уулзалтын ярилцлагаас

Тоон судалгааны үр дүнд хамгийн их тулгамддаг бэрхшээл гэж илэрсэн төсөв санхүүгийн асуудал чанарын судалгааны ярилцлагын үед ч мөн түгээмэл байсан бөгөөд эдгээрээс гадна ялангуяа орон нутгийн залуучуудад мэдээ мэдээлэл хомс байдаг, үйл ажиллагаа хэрхэн зохион байгуулах, залуучуудыг оролцуулах арга, арга зүй дутмаг байдаг, бид бүхэнд хийж хэрэгжүүлэх санал сэдэл олон байдаг ч төрийн байгууллага, бусад ТББ, олон улсын байгууллага зэрэгтэй хэрхэн хамтарч ажиллаж бодит үр дүн болгох тал дээр мэдлэг байдаггүй зэрэг асуудлуудыг дурдсан юм.

Иргэний нийгмийн байгууллагууд ажилчдынхаа дараах ур чадваруудыг 1-5 оноогоор үнэлнэ үү гэсэн асуултад байгууллагууд компьютерын хэрэглээ, харилцаа, төсөл боловсруулах, англи хэлний мэдлэг зэрэг ур чадваруудыг /soft skill/ өндрөөр үнэлсэн бол төсөл хэрэгжүүлэх менежмент, хууль эрх зүйн мэдлэг зэрэг чадваруудыг бусад чадваруудаас доогуур байдаг гэж үнэлжээ.




Зураг 16 ТББ-уудын ажилчдын ур чадварын үнэлгээ

Судалгаанд оролцсон иргэний нийгмийн байгууллагуудын санхүүгийн эх үүсвэрийн хувьд хөрөнгө босгох арга хэмжээ, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөр, бусад эх үүсвэрүүд тус бүр 36.4 хувь байгаа бол хандив 30.3 хувь, харин хамгийн бага нь гишүүдийн хураамж 25.8 хувь байна. Бусад санхүүгийн эх үүсвэрт дотоодын төсөл хөтөлбөр, судалгааны төсөл, ажил үйлчилгээг төрөөс төлбөртэй гүйцэтгэх, сургалт үйл ажиллагаанаас олох төлбөр болон өөрсдийн хөрөнгөөр гэсэн эх үүсвэрүүдийг дурджээ.



Зураг 17 ИНБ-уудын санхүүжилтын хэлбэр

Судалгаанд оролцогч залуучуудын, иргэний нийгмийн байгууллагуудаас “Бүгд залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө” төсөлд хамрагдах сонирхолтой байгаа эсэхийг тодруулахад нийт оролцогчдын 97.1 хувь нь тийм, 2.9 хувь нь үгүй гэж хариулжээ. Оролцох хүсэлтэй бол ямар чиглэлээр хамтран ажиллах сонирхолтой байгаа тал дээр 42.1 хувь нь бусад байгууллагуудаас туршлага солилцох, 43.4 хувь туршлагаа хуваалцах ментор хийх, 14.5 хувь нь бусад ТББ-аас суралцах сонирхолтой байна.



- 43.4% ■ Бусад ТББ-уудад өөрсдийн туршлагаа хуваалцах, ментор хийх
- 14.5% ■ Бусад ТББ-аас суралцах
- 42.1% ■ Бусад ТББ-уудтай туршлага солилцох

Зураг 18 ИНБ-уудын бусад байгууллагуудтай хамтран ажиллах чиглэл

Харин өөр ямар чиглэлээр хамтран ажиллах хүсэлтэй байгааг нээлттэй асуултаар тодруулахад өөрсдийн ажилладаг мэргэшсэн чиглэлээр мэдлэг мэдээллээ хуваалцах, зохион байгуулах үйл ажиллагаанд хамтран оролцох зохион байгуулахад өөрсдийн мэдлэг чадвараар туслах, сургалт зөвлөгөөнд оролцох, залуучуудын оролцоог дэмжих, ментор хөтөлбөрт оролцох зэрэг санал хүсэлтүүдээ илэрхийлжээ. Үүнээс гадна чанарын ярилцлагын үр дүнд ч гэсэн ТББ-ууд хоорондын хамтын ажиллагаа дутмаг, хамтран ажиллах сонирхол их байдаг нь илэрсэн юм.



...Бид бүхэн өөрсдийн аймаг орон нутагтаа үйл ажиллагаа явуулдаг идэвхтэй залуучууд, бусад ТББ-уудаа мэддэг, зарим үйл ажиллагаа дээр ч хамтарч ажилладаг гэсэн хэдий ч өөр бусад аймаг сум, Улаанбаатар хотын ТББ-уудтай тэр болгон хамтарч ажиллаж, туршлага солилцож чаддаггүй. Хэрвээ ийм боломж олдвол бид бүхэнд тулгардаг ижил төстэй асуудлыг шийдвэрлэх сайн туршлага, бодит жишээ зэргээс суралцах мэдлэг мэдээллээ хуваалцах боломжтой болно гэсэн үг...

Баянхонгор аймгийн ИНБ-уудтай хийсэн төслийн уулзалтын ярилцлагаас

Судалгаанд иргэний нийгмийн төлөөллүүдээс тус төслөөс залуучууд, залуучуудын төрийн бус байгууллагыг чадавхжуулах ямар үйл ажиллагаа хүсэж байгааг тодруулахад:

- Менторшип хөтөлбөрт оролцох, ментортой хамран ажиллах
- Төрөл бүрийн чадавхжуулах сургалтууд
- Санхүүгийн асуудлыг хамтран шийдвэрлэх арга зам, хөрөнгө босгох санхүүжилт олох арга, санхүүгийн тусламж
- Иргэний нийгмийн байгууллагуудыг жендэрийн мэдрэмж, мэдлэгтэй болгох, бодлого болон үйл ажиллагаандаа тусгах талаар туршлагатай болгох.
- Ажилчдын ур чадварын хувьд илүү мэргэшүүлэх, шинэ туршлага ур чадварт суралцах
- Засаглал, менежментийн талаар суралцах
- Бусад байгууллагуудтай хамтрах туршлага солилцох, төсөл хөтөлбөрт хамрагдах төсөл бичих, хэрэгжүүлэх зэрэг саналуудыг хэлжээ.

3.3 ТББ-ЫН ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА /ТӨСЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ-2/

Төслийн зорилтот байршлуудад ажилгүйдлийн түвшин 2019 оны байдлаар дараах түвшинд байна. 20-24 насны залуусын ажилгүйдлийн түвшин хамгийн өндөр байна.

Насны бүлэг	Хэнтий	Сэлэнгэ	Дорноговь	Баянхонгор	Улаанбаатар хот
15-19	8	34.5	28.6	0	44.5
20-24	18.6	9.4	3.6	25.5	26.7
25-29	6.7	8.3	3.6	4.2	9.9
30-34	2.7	2.3	7.8	4.3	8.3

Хүснэгт 3 Залуучуудын ажилгүйдлийн түвшин

Судалгаанд хамрагдсан байгууллага, хүмүүсийн 67% нь залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан, 33% нь явуулж байгаагүй. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан байгууллагуудын хувьд дийлэнх нь сургалт явуулж байв.

Д/д	Залуучуудын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Тоо	Хувь
1	Сургалт явуулах	60	48%
2	Зөвлөгөө өгөх үйлчилгээ	38	31%
3	Ажлын байранд зуучлах	24	19%

4	Аян зохион байгуулсан	2	2%
5	Ажлын байраар хангаж байсан	2	2%
6	Аялал зохион байгуулж байсан	1	1%
7	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орчин - мониторинг хийж байсан	1	1%

Хүснэгт 4 Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дээрх үйл ажиллагаанууд явуулж байсан хүмүүсийн 59% нь амжилттай хэрэгжиж байсан, 10% нь амжилтгүй болсон гэсэн бол 31% нь аль аль нь гэж хариулсан байна. Харин амжилтгүй болж байсан шалтгааныг аваад үзвэл үйл ажиллагаа явуулах байр хомс байсан гэсэн хариулт хамгийн их буюу нийт судалгаанд оролцогчдын 94.4% нь хариулсан бол түүний дараа төсөв санхүү хүрэлцээгүй байсан гэж 26.6% нь хариулсан байна. Оролцогчдын хэлсэн шалтгаануудыг доорх хүснэгтэд харуулав.

Д/д	Залуучуудын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Тоо	Хувь
1	Үйл ажиллагаа зохион байгуулах байр орон сууц байгаагүй	117	94.4%
2	Төсөв санхүү хүрэлцээгүй	33	26.6%
3	Хангалттай хүний нөөц байгаагүй	10	8.1%
4	Шаардлагатай техник, тоног төхөөрөмж байгаагүй	9	7.3%
5	Зохион байгуулагч, ажилчдын ур чадвар дутмаг	6	4.8%
6	Үйл ажиллагаанд оролцогчид байгаагүй	4	3.2%
7	Ажил хайгчид идэвхгүй	1	0.8%
8	Гэр бүлийн дэмжлэг, орчны нөөц байгаагүй	1	0.8%
9	Форумд хэтэрхий олон хүн ирээд театр дүүрч зарим нь буцаж байсан	1	0.8%
10	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байранд авах хандлага ойлголт маш дутмаг, мөн тус бүлгийн иргэд маань чадавх тааруу байдаг	1	0.8%
11	Цаг үеийн асуудал, КОВИД-19, сонгууль, багийн гишүүдийн хангалтгүй зохицуулалт	1	0.8%

Хүснэгт 5 Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжүүлэхэд тулгамдаж буй бэрхшээл

Залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулахдаа төрийн байгууллага, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв /МСҮТ/, сургалтын төвүүд болон бусад байгууллага, зөвлөх гэх мэт зохих байгууллагуудтай хамтран ажилласан тохиолдлууд байгаа бөгөөд эдгээрээс бусад байгууллага, зөвлөхүүдтэй хамтран ажилласан нь хамгийн их тохиолдол байна.

Д/д	Хамтран ажилласан байгууллагууд	Тоо	Хувь
1	Бусад байгууллага, зөвлөгч нар	45	33%
2	Сургалтын төвүүд	32	24%
3	МСҮТ	30	22%
4	Төрийн байгууллага	29	21%

Хүснэгт 6 Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хамтран ажилладаг байгууллагууд


Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, бизнес эрхлэлтэд саад болдог, тулгамддаг асуудлуудыг тодруулахад “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд төр, ТББ, бусад байгууллагуудын хамтын ажиллагаа байхгүй” гэсэн хариулт дийлэнх буюу судалгаанд оролцогчдын 43% нь хариулсан байна.

Д/д	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд тулгамддаг саад, бэрхшээл	Тоо	Хувь
1	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд төр,ТББ, бусад байгууллагуудын хамтын ажиллагаа байхгүй	53	43%
2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх чиглэлээр хангалттай сургалт, үйл ажиллагаа явагддаггүй	52	42%
3	Төрөөс залуучуудыг шинэ бизнес эрхлэхэд дэмждэггүй	47	38%
4	Залуучуудад хөдөлмөр, бизнес эрхлэхэд хангалттай хэмжээний мэдлэг, чадвар байдаггүй	45	36%
5	Ажлын байр байдаггүй	43	35%
6	Залуучууд өөрсдөө хөдөлмөр эрхлэх сонирхолгүй байдаг	31	25%
7	Ажилд танил талаа авдаг өөрийн намын хүнээ дэмждэг сум хөгжүүлэх төсөлд намын хүнээ болгодог	1	0.8%
8	Төслийн зээл хангалтгүй	1	0.8%
9	Төсөв санхүүгийн хувьд асуудалтай байдаг	1	0.8%
10	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах хандлага	1	0.8%
11	Хувийн хэвшлийн байгууллагууд ТББ-уудыг доогуур үнэлж, халамж хүртэгч гэж хардаг нь хөрөнгө оруулагч болоход саад учруулдаг.	1	0.8%

Хүснэгт 7 Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр бусад байгууллагуудтай хамтран ажиллахад тулгамддаг бэрхшээл

Судалгаанд оролцогчдоос 29 хүн, байгууллагын төлөөлөл хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ямар нэгэн аппликейшн, программ ашигладаг байна. Ашигладаг хэрэгслийн хувьд Facebook, www.biznetwork.mn цахим сайт, бусад дижитал платформуудыг ашигладаг байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн төрөөс олгодог санхүүжилтийн боломж, хүүгүй зээл, орон нутгийн хөгжлийн сан, бичил зээлийн талаар асуухад дийлэнх хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.



Зураг 19 Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төрөөс явуулж буй үйл ажиллагааны талаарх мэдлэг

Амьдарч буй хот, аймаг, сум орон нутагт нь залуучуудын хөдөлмөр, бизнес эрхлэлтийг дэмжих ямар нөөц, бололцоо байгааг тодруулахад бизнес инкубатор, НУВ төв, жижиг дунд үйлдвэрлэлийн газар байдаг, бизнес эрхлэх газар, байрыг зохицуулах боломжтой, харилцаа холбоо сайтай зэрэг давуу талуудыг хэлж байгаа бол орон нутагт өрсөлдөөн бага, зах зээл шинэ, мал аж ахуй, хөдөө аж ахуй, газар тариалан, өрхийн аж ахуй эрхлэх боломжтой, аялал жуулчлал гэсэн хариултауд өгсөн байна. Харин Улаанбаатар хотоос хамрагдсан хүмүүс залуучуудыг үнэлдэггүй гэсэн сул талыг хэлсэн бол орон нутгаас хамрагдсан хүмүүсийн хувьд мэдээлэл дутмаг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нөөц бололцоо хангалтгүй, ажлын байр бага зэрэг сул талуудыг нэрлэсэн байна.

Улаанбаатар хот	Орон нутаг
Бизнес инкубатор төв	Өрсөлдөөн бага
НУВ төв	Залуучууд ихтэй
Жижиг дунд үйлдвэрлэлийн газар	Шинэ зах зээл их
Бизнес эрхлэх байр	МАА
Харилцаа холбо сайтай	ХАА, газар тариалан
Хүн ам ихтэй	Өрхийн бизнес
Ажлын байр ихтэй	Аялал жуулчлал

Хүснэгт 8 Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, бизнесийг дэмжих нөөц, бололцоо

3.4 ТББ-ЫН ЗАЛУУЧУУДЫН ИРГЭНИЙ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА /ТӨСЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ-3/

Залуучуудын эрх ашгийг хамгаалах чиглэлээр ямар үйл ажиллагаа хэрэгжүүлж байсныг тодруулахад олон нийтэд хандсан уриалга явуулж байсан гэсэн хариулт хамгийн олон байна. Нийт хариултуудаас харахад эрх ашгийг хамгаалах чиглэлээрх үйл ажиллагаа нь уриалга, цахим аян, цуглаан, эвентээр хязгаарлагдаж байна.

Д/д	Залуучуудын иргэний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээрх үйл ажиллагаа	Тоо	Хувь
1	Олон нийтэд хандсан уриалга явуулах	64	52%
2	Цахим хөдөлгөөн өрнүүлэх	49	40%
3	Төр, засгийн газрын байгууллагуудад албан бичиг хүргүүлэх	24	19%
4	Жагсаал цуглаан зохион байгуулах	15	12%
5	Public art, land art-ын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг.	1	1%
6	Зөвлөгөө өгдөг	1	1%
7	Оролцох боломжийг дэмжих	1	1%
8	Соёл урлагаар дамжуулан хандлагыг өөрчлөх олон улсын хэмжээнд чанарын хувьд хүрэхүйц эвентүүд зохион байгуулах	1	1%
9	Сургалт	1	1%

Хүснэгт 9 Залуучуудын иргэний оролцооны чиглэлээр явуулдаг үйл ажиллагаа

Судалгаанд хамрагдсан байгууллага, бүлгэм, хүмүүсийн хувьд 60% нь залуучуудын иргэний оролцог нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан байна. Харин ямар төрлийн үйл ажиллагаа явуулж байсныг тодруулахад уулзалт, хэлэлцүүлэг, подкаст, иргэдийн хуралд оролцох гэх мэт төрөл бүрийн үйл ажиллагааг нэрлэж байв. Эдгээрийг төрлөөр нь ангилж харвал төрийн байгууллагын шийдвэр гаргалтад нөлөөлөх, саналаа өгөх, хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын байгууллагуудын хувьд өөрсдийн дуу хоолойг нийгэмд түгээх, нөлөөлөх, сургалт хийх, оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулахад чиглэсэн сургалт, тэтгэлэгт хөтөлбөр, уулзалт, хэлэлцүүлэг, сайн дурын ажлыг хэрэгжүүлж байсан туршлагауд байна. Нээлттэй асуултад ирүүлсэн хариултуудыг харвал:

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭР ГАРГАЛТАД ОРОЛЦОХ

- Хороо, дүүргийн иргэдийн хуралд оролцож санал гаргадаг
- Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг залуучуудад таниулах, өөрчлөлтөд оролцуулах, мэдээлэлжүүлэх
- Үндсэн хуульд иргэдийн оролцоо цахим аян

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦОО	<ul style="list-style-type: none">• "БИД ӨӨРЧЛӨГЧИД" флашмоб нөлөөлийн арга хэмжээг Улаанбаатар хотын 500 гаруй хүмүүсийн дунд зохион байгуулсан ба орон нутгийн 5 аймгийн төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж байсан.• Хөдөлмөр эрхлэхэд "Хаалгаа нээ" гэдэг үзэсгэлэн худалдааг Оюуны ялгаатай чадвартай залуусын хийсэн бүтээгдэхүүнийг борлуулах зорилгоор 2019 онд хийсэн• 1000 гаруй гишүүдтэй клубээр дамжуулан сошиал орчинд залуучуудад нийгмийн бүхий л төрлийн хэрэгцээг мэргэжлийн хүмүүсийн зөвөлгөөг хэлмэрчтэй орчуулан шууд хүргэдэг тогтмол контент хийдэг
ТОДОРХОЙ САЛБАР, ЧИГЛЭЛЭЭР МАНЛАЙЛАЛ	<ul style="list-style-type: none">• Залуу эхчүүдийг чадваржуулах хөтөлбөр, Охидын чуулган, Охидын манлайллын хөтөлбөр• Хүний эрхийн залуу манлайлагч төсөл
УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ	<ul style="list-style-type: none">• Жижиг дунд бизнес эрхлэгчдийн дунд уулзалт хэлэлцүүлэг, үзэсгэлэн худалдаа, бизнес аялал зохион байгуулдаг• Залуучуудын хөгжлийн чуулган, хурал хэлэлцүүлэг• Лекц, хэлэлцүүлэг• Мэтгэлцээн хөтөлбөр
БУСАД ЧИГЛЭЛЭЭР	<ul style="list-style-type: none">• Эрх зүйн хөтөч бэлтгэх төсөл, сайн дурын ажилтнуудыг идэвхижүүлэх, подкастаар мэдлэг олгох дугаарууд• Залуучуудын бодлого шийдлийн хакатон, Судалгааны тэтгэлэгт хөтөлбөр, Мэтгэлцээн хөтөлбөр, Мэтгэлцээний цахим сургалтын платформ г.м• 100 залуу төсөл• Street art festival, contemporary art events, Хайрын гудамж төсөл, сэтгэлзүйн дархлаа хөтөлбөр


Зураг 20 ИНБ-уудын иргэний оролцооны чиглэлээр ажиллаж байсан туршлага

Судалгаанд хамрагдсан 124 оролцогчийн 45 буюу 36% нь залуучуудын хөгжил, иргэний оролцооны талаар үүрэг хүлээсэн төр, засгийн газрын байгууллагуудтай хамтран ажиллаж байсан байна. Эдгээр байгууллагуудын төрийн байгууллагатай хамтран ажилласан чиглэлийг харахад сургалт, уулзалт, хэлэлцүүлгийн ажлууд түлхүү хийгдсэн байна. Мөн түүнчлэн санхүүжилт хүсэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, төсөл хэрэгжүүлэх хүрээнд хамтран ажилладаг байна. Жишээлбэл:



Зураг 21 ИНБ-уудын төр засгийн байгууллагуудтай хамтран ажиллаж буй чиглэл

Залуучуудад төрөөс явуулж буй бодлого, шийдвэр, үйл ажиллагаа хэр зэрэг ил тод, нээлттэй байдаг вэ гэсэн асуултад дийлэнх буюу 65% нь дунд зэрэг гэж хариулсан байна.



Зураг 22 ИНБ-уудын төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлын үнэлгээ

Залуучуудын чиглэлээр хүчин төгөлдөр хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийн талаар асуухад судалгаанд хамрагдсан байгууллага, хүмүүсийн **талаас илүү хувь нь үгүй, мэдэхгүй гэж хариулсан байна.**

Бодлого, хөтөлбөрийг
уншиж байсан эсэх



- Залуучуудын Хөгжлийг Дэмжих Тухай Хууль
- Залуучуудын Хөгжлийн Үндэсний Хөтөлбөр
- Өөрийн дүүрэг, аймаг, суманд хэрэгжиж байгаа Залуучуудын Хөгжлийн дэд хөтөлбөрүүд

Зураг 22а ИНБ-уудын бодлого, хөтөлбөрийн талаарх мэдээлэл

Иргэний оролцооны ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулж буйг эсвэл байсан эсэхийг тодруулахад уриалга, үзэл бодлоо илэрхийлэх тал дээр арай илүү оролцоотой, төрийн бодлого, шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох, харьяа дүүрэг, орон нутгийнхаа залуучуудын төв, орон нутгийн хөгжлийн санд саналаа өгөх зэрэг дуу хоолойгоо илэрхийлэх хэлбэрийн дараагийн шатны, илүү оролцоо шаардсан үйл ажиллагаанд оролцож байсан хүмүүс илүү бага хувьтай байна.

Үзэл бодлоо илэрхийлэх

Идэвхитэй оролцох

52% Залуучуудыг иргэний эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхийг уриалсан, дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг

48% Нийгмийн төрөл бүрийн залуучуудын бүлгийн хөгжил, оролцоо, эрх ашгаа хамгаалах, үзэл бодлоо илэрхийлэх аливаа үйл ажиллагаанд оролцдог

36% Залуучуудыг сонгуульд идэвхтэй оролцохыг уриалсан, дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг

34% Төрийн бодлого тодорхойлох, шийдвэр гарах үйл явцад идэвхтэй оролцдог

33% Өөрийн дүүрэг, аймаг, суманд байдаг залуучуудын Хөгжлийн Төвөөр үйлчлүүлдэг

22% Орон нутгийн хөгжлийн санд саналаа оруулдаг

Зураг 23 ИНБ-уудын оролцооны байдал


“Бүгд залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө” төслөөр дамжуулан залуучуудын иргэний оролцоог дэмжих ямар үйл ажиллагаа зохион байгуулах саналтай байгааг тодруулахад **сургалт болон оролцоог идэвхжүүлэх төсөл гэсэн саналууд хамгийн их давтагдав.**



Зураг 24 Иргэний оролцооны дэмжих чиглэлээр үйл ажиллагаа


3.5 ЗАЛУУЧУУДЫН САЙН ДУРЫН АЖЛЫГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА /ТӨСЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ-4/

Судалгаанд хамрагдагчдын 53.8 хувь нь залуучуудын сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөртэй бол 46.2 нь байхгүй байна. Үүнийг давтамжийн тоогоор авч үзвэл нийт судалгаанд оролцсон 46 бүртгэлтэй ТББ-ын 25 байгууллага нь хөтөлбөртэй бол 21 байгууллага нь хөтөлбөргүй байна. Харин 65.6 хувь нь сайн дурын ажилчдаа сургалтад хамруулдаг 34.4 нь үгүй гэж хариулжээ. Сургалтад хамрагддаг иргэний нийгмийн байгууллагуудын 73.3 хувь нь жилд дунджаар 1-3 сургалтад, 13.3 хувь нь 4-6 сургалтад, 4.4 хувь нь 7-10 сургалтад, 8.9 хувь нь 11 болон түүнээс дээш сургалтад хамруулдаг байна. Улаанбаатар хот болон аймгуудаар харьцуулан харвал Хэнтий аймгийн иргэний нийгмийн төлөөллүүдийн ихэнх хувь нь буюу 66.7 хувь нь сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөр байхгүй гэжээ. Бусад байршлуудын хувьд тал орчим хувь нь мөн л сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөргүй байна.



Зураг 25 ИНБ-ууд сайн дурын ажлын хөтөлбөртэй эсэх, байршлаар

Иргэний нийгмийн байгууллагуудын 65.6 хувь нь сайн дурын ажилчдаа сургалтад хамруулдаг гэсэн бол үлдсэн 34.4 хувь нь сургалтад хамруулдаггүй гэжээ. Сургалтад хамруулдаг байгууллагуудын хувьд 61 хувь нь жилд дунджаар 10-20 цагийн сургалт өгдөг байна.



Зураг 26 Сайн дурын ажилчдаа жилд сургалтад хамруулдаг цаг

ТББ-ууд сайн дурын ажилчдаа урамшуулдаг эсэхийг тодруулахад 34.6 хувь нь урамшууллын тогтолцоо байхгүй, 36.5 хувь нь төслөөс хамааран урамшуулдаг, 15.4 хувь нь сайн дурын ажил бүрд урамшуулдаг, 7.7 хувь нь бусад буюу сертификат өгөх, байгууллагаас гаргасан ном товхимлоор урамшуулах, бага хэмжээний мөнгөн урамшуулал олгох зэргээр урамшуулдаг байна.




Зураг 27 Сайн дурын ажилчдын урамшууллын тогтолцоо

ТББ-уудын сайн дурын ажлын хууль эрх зүйн мэдлэгийн тухайд: Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх баталгаажуулах журамтай байгууллагуудын ихэнх хувь нь буюу 62.1 хувь нь танилцаагүй, харин Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн залуучуудын сайн дурын ажилтай холбоотой хэсэгтэй судалгаанд оролцогчдын тал хувь нь танилцсан бол үлдсэн тал хувь танилцаагүй байна. Үүнээс үзэхэд ТББ-уудын хувьд үйл ажиллагаатай нь холбогдож буй хууль журмын талаарх мэдлэг бага байна.



Зураг 28 ИНБ-уудын сайн дурын үйл ажиллагааны талаарх хууль, журмын талаарх мэдлэг

Танай байгууллагад сайн дурын ажилтнуудыг үйл ажиллагаандаа оролцуулахад шаардлагатай мэдлэг мэдээлэл хангалттай гэж үнэлэх үү? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын ердөө 3.3 хувь нь бүрэн хангалттай, 25.0 хувь нь хангалттай гэж үзсэн бол тал орчим хувь нь буюу 48.3 хувь нь дунд зэрэг байдаг, үлдсэн 23.3 хувь нь хангалтгүй болон огт хангалтгүй гэж үнэлжээ.



Зураг 29 Сайн дурын ажилчдыг үйл ажиллагаандаа оролцуулахад хангалттай мэдлэг бий эсэх

Судалгаанд иргэний нийгмийн төлөөллүүдээс төслөөс залуучуудын сайн дурын ажлыг дэмжих ямар ажил хийвэл үр дүнтэй гэж үзэж байгааг тодруулахад


- Сайн дурын ажилчдад мэдээлэл түгээх систем бий болгох
- Сайн дурын ажлын талаар зөв мэдлэг мэдээлэл өгөх, зөв сэдэлжүүлэх, үр дүнтэй сайн дурын ажил хийх талаар залуучуудад хүргэх, мэдлэг мэдээллээр хангах
- Сайн дурын ажлыг үр дүнтэй удирдан зохион байгуулах сургалт, бодит туршлага судлах

- Их дээд сургуулийн хөтөлбөрт сайн дурын ажилд кредит өгдөг систем бий болгох тал дээр хамтран ажиллах сайн дурын ажлыг урамшуулах, үнэлэх шинэ зөв санал санаачилгыг гаргах болон залуучуудын өөрсдийнх нь идэвх санаачилга дээр сайн дурын ажил зохион байгуулах
- Сайн дурын ажилд залуучуудыг зөв сэдэлжүүлэх тал дээр ажиллах

Сайн дурынхны сонгон шалгаруулалт, сайн дурынхны менежментийн сургалт зохион байгуулж, хамтран сайн дурынхныг сонгон шалгаруулах үйл ажиллагаа зохион байгуулах, сайн дурынхны цагийг үнэлэх үнэлгээний арга зүйг хуваалцах, түгээж ажилласнаар сүлжээнд нэгдсэн байгууллагууд цаашид сайн дурынхныг тогтвортой, үр нөлөөтэйгөөр үйл ажиллагаагаа төлөвлөж явуулах боломжтой болгох зэрэг санал хүсэлтүүдийг илэрхийлжээ.

3.6 КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ


Судалгаанд оролцсон иргэний нийгмийн төлөөллүүдээс Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотой байгууллагын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлсөн талаар тодруулахад нийт оролцогчдын 50 хувь нь сөргөөр нөлөөлсөн гэж үзсэн бол 14.5 хувь нь нөлөөлөөгүй, 14.5 хувь нь шинэ боломж бий болгосон, 21.0 хувь эерэг болон сөргийн аль алианаар нь нөлөөлсөн гэж хариулсан байна.



Зураг 30 Ковид-19 нөхцөл байдлын нөлөөлөл

Сөргөөр нөлөөлсөн гэж үзэж буй байгууллагууд хэрэгжүүлэх ёстой байсан төлөвлөгөөт үйл ажиллагаанууд тодорхойгүй шалтгаанаар хойшилсон, үйл ажиллагааны хэвийн тогтвортой байдал алдагдсан, байгууллагын ажилчид ирж ажиллах боломжгүй болсноор сэтгэл санаа, эдийн засгийн хувьд хохирсон, олон төлөвлөөгүй үргүй зардал гарсан, санхүүгийн хувьд бэрхшээл тулгарсан, олон нийтийг хамарсан бүх үйл ажиллагаа, сургалт семинарууд хойшилж төлөвлөгөөт санхүүжилтүүд олгогдоогүй зэрэг бэрхшээлүүдийг илэрхийлжээ.

Харин шинэ боломж бий болгосон гэж үзсэн байгууллагуудын хувьд онлайнаар мэдээлэл авах, зайнаас ажиллах талаар шинэ туршлага мэдлэгтэй болсон, дотоод үйл ажиллагаагаа цэгцлэх хянах боломж бий болсон, оюутнууд амарсан тул оюутнуудыг татах гишүүнчлэлээ нэмэх боломж бий болгосон, цахим орчинд контент бэлтгэх цацах зэрэг шинэ боломжуудыг олгосон гэжээ.



Зураг 31 Ковид-19 нөхцөл байдалтай холбоотой бэрхшээл, боломжийг ашиглаж байгаа эсэх

Шинэ нөхцөл байдлаас үүдсэн бэрхшээлийг даван туулж боломжийг ашиглаж чадаж байгаа эсэхийг иргэний нийгмийн байгууллагуудаас тодруулахад 70.7 хувь нь бэрхшээлийг даван туулж чадаж байна, 68.8 хувь нь боломжийг ашиглаж чадаж байна гэж үзжээ.

Нөхцөл байдалтай холбоотой боломжийг ашиглахад танай байгууллагад ямар тусламж дэмжлэг хэрэгтэй байна гэсэн асуултад:

- Нөхцөл байдалтай холбоотой шинэ мэдлэг мэдээлэл хөтөлбөр бүхий чиглүүлэх сургалт явуулах, мэдлэг стратеги оновчтой төлөвлөгөө бий болгоход туслах
- Бусад ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай холбогдож, хамтран ажиллах, туршлага солилцох
- Санхүүгийн дэмжлэг туслалцаа болон онлайн үйл ажиллагаанд хэрэгтэй тоног төхөөрөмжийн дэмжлэг
- Хүмүүст эрүүл мэндийн болон шаардлагатай үед өөрийгөө эрсдэлээс гаргах бэлтгэлтэй байлгах талаар нэмэлт сургалт хийхэд дэмжлэг хэрэгтэй байна гэж үзжээ.

Нөхцөл байдалтай холбоотой бэрхшээл саадыг даван туулахад танай байгууллагад ямар тусламж дэмжлэг хэрэгтэй байна гэсэн асуултад:

- Санхүү, шаардлагатай тоног төхөөрөмж материалын дэмжлэг туслалцаа
- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө сайжруулах тал дээр зөвлөн туслах, нөхцөл байдалтай холбоотой шинэ ур чадвар, бодлого, төлөвлөлт
- Онлайн сургалтын арга барил, засаглал арга зүйн зөвлөгөө авах
- Байгууллагууд хоорондоо даван туулж буй сайн туршлага хуваалцаж, хамтран ажиллаж, харилцан суралцах, хөгжих боломжуудыг илүү нэмэгдүүлэх шаардлагатай байна. Гадаад дотоодын бусад байгууллагуудын сайн туршлага хэрэгтэй байна.

Нөхцөл байдалтай холбоотой тулгарч буй бэрхшээл саадыг даван туулахад ямар санал шийдэл байгаа талаар тодруулахад

- Ихэнх байгууллагууд цахим орчин ашиглан үйл ажиллагаагаа зохион байгуулах, цахим контент бэлтгэн залуучуудад түгээх, цахимаар залуучуудыг идэвхжүүлэх ажлуудыг хийх, энэ тал дээр хүний нөөцийг бэлтгэх

- Урьдчилан сэргийлэх сургалт, хөдөлмөрийн зах зээлийн шинэ орчныг яаж бүрдүүлэх, хэрхэн хамтарч ажиллах, судалгаа хийх, хөрөнгийн хөдөлгөөнд дүн шинжилгээ хийх, хуримтлал хэрхэн бий болгох, болзошгүй нөхцөлд хэрхэн ажиллах зэрэг асуудлыг судалж шийдвэрлэх хэрэгтэй
- Цаг үед нийцсэн шинэ хүртээмжтэй бодлого төлөвлөгөө хамтран боловсруулах
- Энэ үед судалгаа, оновчтой зохион байгуулалт хийж бизнесээ урагшлуулах алхам хийх хэрэгтэй. Менежментээ өөрчлөх хэрэгтэй
- Инновацыг хөгжүүлэх, технологийн талаар шийдэл боловсруулах зэрэг санал шийдлүүдийг илэрхийлжээ

3.7 ЗАЛУУЧУУДЫН БАЙГУУЛЛАГУУДАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудад тулгамдаж буй асуудлуудыг авч үзвэл санхүүжилт, санхүүжилт олох талын мэдлэг мэдээлэл хангалтгүй байдаг байна. Мөн түүнчлэн иргэний нийгмийн байгууллагуудын дунд зохион байгуулагдсан уулзалт,хурал дээр төрийн байгууллагуудын зүгээс дэмжлэг туслалцаа, хамтын ажиллагаа бага, тодорхой дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлүүлэхэд бэрхшээлтэй, чадвартай гишүүд дутмаг байдаг зэрэг асуудлууд олон давтагдаж байлаа. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад дуу хоолойгоо өргөх, санал санаачилгаа хэрэгжүүлэхэд санхүүжилтээс гадна чадвартай залуус дутмаг байдаг талаар дурдаж байв. Нээлттэй асуултын хариултаас олон давтагдсан тулгамдаж буй асуудлын талаарх хариултаудыг нэгтгэн харвал дараах байдалтай байна.

Тулгамдаж буй асуудал	Санхүүжилт олдохгүй байх-15 санал
	Төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдах туршлага дутах-7 санал
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлах-3 санал
	Гишүүдийн идэвх, чадавх сул байх-10 санал
	Төрийн байгууллагаын дэмжлэг, хамтын ажиллагаа дутмаг-11 санал

Зураг 32 Тулгамдаж буй асуудал

Харин залуучуудын хэрэгцээ, шаардлага ямар байгааг харахад дээрх асуудлуудыг шийдвэрлэхэд хамгийн эхэнд сургалт, санхүүжилт босгох, төсөл бичих, төсөл хөтөлбөрт хамрагдах чиглэлээрх сургалт, гишүүдэд манлайлал, чадавхжуулах үйл ажиллагаа, бусад байгууллагуудаас туршлага солилцох, хамтран ажиллах, ажилд зуучлах үйл ажиллагаа явуулах зэрэг үйл ажиллагаа хэрэгцээтэй байна гэсэн санал хамгийн их давтагдсан байна. Үүнээс залуучуудын чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудад зөвхөн **санхүүгийн дэмжлэгээс гадна чадавхжуулах сургалтууд хэрэгцээ шаардлагатай байгаа нь харагдаж байна.**

БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1 ДҮГНЭЛТ

- Судалгаанд иргэний нийгмийн төлөөлөл болсон нийт 124 оролцогч хамрагдсанаас хүйсийн хувьд эмэгтэй 57 хувь, эрэгтэй 43 хувь байна.
- Судалгаанд оролцсон байгууллагуудын 97 хувь нь төсөлд хамрагдах хүсэлтэй, ингэхдээ харилцан туршлага солилцох замаар хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлжээ. Мөн түүнчлэн судалгааны мэдээлэл цуглуулалтын явцад судалгаанд хамрагдаагүй зарим байгууллагууд төсөлд хамрагдах сонирхолгүй байгаа гэсэн тохиолдлууд гарсан.

Төслийн үндсэн чиглэл 1: ТББ-уудыг чадавхжуулах ажлын хувьд

- Байгууллагуудын хүний нөөцийн хувьд дийлэнх нь 5 хүртэлх удирдах албан тушаал, 10 хүртэлх үндсэн ажилчид, 50 хүртэлх гишүүдтэй байгууллагууд байна. Жендэрийн хувьд ИНБ-уудын удирдах албан тушаалтны 50 хувь нь эмэгтэй байгаа бол бусад үндсэн ажилчид, сайн дурын ажилтан, гишүүдийн хувьд ихэнх хувийг буюу 51-ээс дээш хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Үүнээс харахад иргэний нийгмийн үйл ажиллагаанд эмэгтэй хүмүүс илүү зонхилох хандлагатай байна.
- Салбар нэгж байхгүй байгууллагууд дийлэнх буюу 40.3% эзэлж байна. 56.5% нь үйл ажиллагаа тогтмол явуулдаг, 2.9% нь хагас жилд 1 удаа үйл ажиллагаа явуулдаг гэсэн байгаа нь дийлэнх байгууллагуудын үйл ажиллагаа харьцангуй тогтмол байгааг харуулж байна.
- Жилд хэрэгжүүлж буй төсөл үйл ажиллагааны хувьд тал хувь нь буюу 52.2 хувь нь жилд 1-5 төсөл хэрэгжүүлдэг бол 28.4 хувь жил бүр төсөл үйл ажиллагаа хэрэгжүүлж чаддаггүй байгаагаас харахад тогтмол төсөл, үйл ажиллагаа хэрэгжүүлдэг болох чадавх сайн бүрэлдээгүй байна.
- Мөн дийлэнх буюу 92.6% нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөтэй, 74.6% нь урт болон богино хугацааны стратеги төлөвлөгөөтэй байгаа нь судалгаанд хамрагдсан байгууллагуудын дийлэнх нь тодорхой хэмжээгээр үндсэн бичиг баримтаа боловсруулж, бэлтгэдэг болохыг харуулж байна. Гэсэн хэдий ч энэхүү судалгааны хүрээнд аливаа байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийгээгүй тул тус баримт бичгүүдийн оновчтой боловсруулсан, хэрэгжилт ямар байдаг эсэхийг тодорхойлох боломжгүй юм. Үйл ажиллагааны тогтмол байдал, хэрэгжүүлж байсан төсөл, хөтөлбөр үйл ажиллагааны тоо, жишээг харахад байгууллагын үндсэн бичиг баримтыг тодорхой хэмжээгээр боловсруулсан хэдий ч, амжилттай хэрэгжилт эсвэл оновчтой зөв тодорхойлсон эсэх дээр чадавхыг нарийвчлан тодорхойлох, тохирсон чиглэлээр чадавхжуулах шаардлагатай харагдаж байна.
- Төслийн үндсэн 4 зорилт болох хөдөлмөр эрхлэлт, сайн дурын ажил, иргэний оролцоо гэсэн чиглэлүүдтэй судалгаанд хамрагдсан ИНБ-уудын хамгийн өргөн хэрэгжүүлдэг үйл ажиллагааны чиглэл ижил төстэй буюу төсөлд хамрагдах

байгууллагууд тухайн чиглэлээр хамтран ажиллах туршлага солилцох боломжтой байна.

- Төрөөс явуулж буй бодлого шийдвэр хууль эрх зүйн мэдлэгийн, хэрэгжилтийн хувьд энэ талаарх мэдлэг хангалттай сайн биш, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж чаддаггүй болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Мөн төрийн бодлого, хууль журмын талаарх мэдлэг төслийн байршил бүрд харьцангуй ялгаатай байгаа бөгөөд Баянхонгор аймгийн хувьд хамгийн муу үзүүлэлттэй байна. Ерөнхийдөө судалгаанд хамрагдсан байгууллагуудын хувьд эрх зүйн мэдлэг, хэрэгжилт хангалтгүй байгаа нь харагдлаа.
- Төрийн бус байгууллагуудад хамгийн их тулгардаг бэрхшээлийг төсөв санхүүгийн асуудал, төрийн дэмжлэг хамтын ажиллагаа муу, гишүүдийн идэвх сул гэж тодорхойлж байна.

Төслийн үндсэн чиглэл 2: ТББ-уудын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хувьд

- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ТББ-ууд ихэвчлэн сургалт, зөвлөгөө, форум, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах үйл ажиллагаанууд хэрэгжүүлж байсан туршлагатай байна. Харин залуучуудын хөдөлмөр эрхлэлт, бизнес эрхлэлтэд саад болдог, тулгамддаг асуудлуудаас “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд төр, ТББ, бусад байгууллагуудын хамтын ажиллагаа байхгүй” гэсэн хариулт дийлэнх буюу судалгаанд оролцогчдын 43% нь хариулсан. Энэ нь залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд нь өргөн хүрээнд биш, сургалт, форум төдийгөөр хязгаарлагддаг, мөн байгууллага хоорондын хамтын ажиллагаа сул байгааг харуулж байна.
- Залуучуудын хөдөлмөр, бизнес эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн төрөөс олгодог санхүүжилтийн боломж, хүүгүй зээл, орон нутгийн хөгжлийн сан, бичил зээл гэх мэт мэдээллүүдийн талаар дөнгөж 10% нь сайн мэддэг, 36% нь огт мэдээгүй гэж хариулсан нь залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ, бүлгүүд өөрсдийн хуулиар олгогдсон, төрөөс олгож буй дэмжлэг, боломжийн талаар ойлголт, мэдлэг хангалтгүй байгааг харуулж байна. Нөгөө талаас эдгээр мэдээллийг холбогдох төрийн байгууллагууд нийтэд ил тод, нээлттэй болгох хэрэгтэйг мөн харуулж байна.
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрхэн хамтарч ажиллах сонирхолтой байгааг асуухад дийлэнх тохиолдолд тодорхой хариулт гараагүй, сургалт, манлайлал, ажилд зуучлал, чадавхжуулах гэсэн хариултууд давтагдсан байгаа нь байгууллага, иргэний нийгмийн төлөөллүүд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр оновчтой үйл ажиллагааны төлөвлөгөөгүй, тодорхой бус байгаа нь харагдаж байна. Иймд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээрх үйл ажиллагаа танхимын сургалтаар хязгаарлагдах төдий биш, илүү практик, үр дүнтэй байлгахад анхаарах нь чухал юм.

Төслийн үндсэн чиглэл 3: ТББ-уудын иргэний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээрх үйл ажиллагааны хувьд

- Залуучуудын иргэний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагааг тодруулахад 52% нь олон нийтэд хандсан уриалга явуулах, 40% нь цахим хөдөлгөөн өрнүүлэх, 19% нь төр, засгийн газрын байгууллагуудад албан бичиг хүргүүлэх, 12% нь жагсаал цуглаан зохион байгуулах зэрэг үйл ажиллагаанууд хийж байсан байна. Үүнээс харахад залуучуудын чиглэлээр ажиллаж буй ТББ-ууд, иргэний нийгмийн байгууллагууд иргэний оролцоог нэмэгдүүлэх хүрээнд хэрэгжүүлдэг үйл ажиллагаа нь хязгаарлагдмал буюу уриалга, цуглаан, албан бичиг төдийгөөр хязгаарлагдаж байна. Өөрөөр хэлбэл залуучуудын идэвхтэй, утга учиртай, бодит оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байгааг үүнээс харж болно.
- Төр, засгийн газрын байгууллагуудтай хамтран олон нийтэд мэдээлэл түгээх, сургалт орох, нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлж байсан туршлагатай байна. Харин ямар нэгэн бодлого, шийдвэрт нөлөөлөх, өөрсдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр оролцоотой байх буюу дуу хоолойгоо илэрхийлэх ажил хийгддэг бол шийдвэр гаргах шатны оролцооны чиглэлээр үйл ажиллагаа явуулсан туршлага хомс байна. Тухайлбал хороо, дүүргийн иргэдийн хуралд оролцож саналаа илэрхийлж байсан гэж ганцхан хүн хариулсан байна.
- Судалгааны явцад, ялангуяа чанарын ярилцлагын үеэр судалгаанд оролцогчдын зүгээс ажиглагдсан нэг зүйл бол иргэний оролцоо гэдэг үгийг, түүний мөн чанарыг ойлгохгүйгээр, илүү уриа, лоозонгийн хэлбэрээр хэтрүүлэн хэрэглэж байсан явдал юм. Мөн энэ үгийг судалгаанд оролцогчид харилцан адилгүй байдлаар ойлгож байсан. Иймд нэг талаас, энэхүү төслийн хүрээнд иргэний оролцоо гэсэн үгийг энгийн, ойлгомжтой байдлаар тодорхойлох шаардлагатай гэж үзэж байна. Нөгөө талаас, иргэний оролцоог зөвхөн төрийн үйл ажиллагаа, шийдвэр/бодлогод нөлөөлөх, оролцох оролцоогоор хязгаарлаж байгаа байдал ажиглагдсан. Амьдралд ойр, практикал буюу хүн өөрийнхөө өдөр тутмын амьдралын чанарыг сайжруулахад иргэн, оршин суугч, залуу хүнийхээ хувьд хэрхэн оролцох, мэдээллийг хаанаас авах, шаардлагаа хэрхэн, хаана, хэнд тавих тухай огт яригдахгүй байгаа нь учир дутагдалтай юм.
- Мөн судалгаанд хамрагдагсад залуучуудын чиглэлээр хэрэгжиж буй албан ёсны бодлого, хууль тогтоомжуудыг талаас илүү хувь нь мэдэхгүй гэж хариулсан байгаа нь иргэний оролцооны чиглэлээр хэрхэн оролцох, төрөөс хэрхэн дэмжигдсэн байгаа зэрэг өөрсдийн ажиллаж буй салбарынхаа талаар хууль эрх зүйн мэдээлэл хомс байгааг харуулж байна.

Төслийн үндсэн чиглэл 4: ТББ-уудын сайн дурын ажлыг дэмжих чиглэлээрх үйл ажиллагааны хувьд

- Судалгаанд хамрагдагсдын 53.8 хувь нь залуучуудын сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөртэй бол 46.2 нь байхгүй байна. 65.6 хувь нь сайн дурын ажилчдаа сургалтад хамруулдаг бол 34.4 нь үгүй гэж хариулжээ. Үүнээс харахад сайн дурын ажлын талаарх зөв ойлголттой байгууллага дийлэнх хувь эзэлж буйг харуулж байна. Харин хөтөлбөр, сургалтын агуулга, чанарын хувьд хэр үр дүнтэй, чанартай

боловсруулагддаг талаас нь авч үзэхэд сайн дурын ажилтны цогц хөтөлбөр, сургалтын агуулга талаас нь чадавхжуулах шаардлагатай байгаа нь зарим ярилцлагад оролцогчдын мэдээллээс харагдаж байлаа. Тухайлбал, ярилцлагын явцад сайн дурын ажилтныг ажиллуулахад ажлын төлөвлөгөө гаргаж өгдөг, хийх ажлын танилцуулга, сургалт хийдэг талаар дурдагдаж байсан нь сургалт, хөтөлбөрийн агуулга нь танилцуулга, ажлын төлөвлөгөө гэх мэт үндсэн мэдээллээр хязгаарлагддаг байх магадлалтайг харуулж байв.

- Сургалтад хамруулдаг байгууллагуудын хувьд 61 хувь нь жилд дунджаар 10-20 цагийн сургалт өгдөг байна. ТББ-ууд сайн дурын ажилчдаа урамшуулдаг эсэхийг тодруулахад 34.6 хувь нь урамшууллын тогтолцоо байхгүй, 36.5 хувь нь төслөөс хамааран урамшуулдаг, 15.4 хувь нь сайн дурын ажил бүрд урамшуулдаг, 7.7 хувь нь бусад буюу сертификат өгөх, байгууллагаас гаргасан ном товхимлоор урамшуулах, бага хэмжээний мөнгөн урамшуулал олгох зэргээр урамшуулдаг байна. Сургалт, урамшууллын тогтолцоо бүрэлдсэн байгууллагууд дийлэнх хувийг эзэлж байгаа нь сайн дурын ажилтны үнэлгээ, дэмжлэгийг хэрэгжүүлдэг судалгаанд хамрагдсан байгууллагууд хэрэгжүүлдэг болохыг харуулж байна.
- ТББ-уудын сайн дурын ажлын хууль эрх зүйн мэдлэгийн тухайд Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх баталгаажуулах журамтай байгууллагуудын ихэнх хувь нь буюу 62.1 хувь нь танилцаагүй, харин Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн залуучуудын сайн дурын ажилтай холбоотой хэсэгтэй судалгаанд оролцогчдын тал хувь нь танилцсан бол үлдсэн тал хувь танилцаагүй байна. Энэ нь ТББ-уудын хувьд үйл ажиллагаатай нь холбогдож буй хууль журмын талаарх мэдлэг бага байна. Мөн өөрсдийгөө сайн дурын ажилтнуудыг үйл ажиллагаандаа оролцуулахад шаардлагатай мэдлэг мэдээлэл хангалтгүй гэж үздэг, ердөө 3.3% нь хангалттай гэж үзэж байгаа нь цаашид сайн дурын ажилтнуудыг хэрхэн дэмжих чиглэлээр илүү мэдлэг, ойлголт өгөх шаардлагатай байгааг харуулж байна.

КОВИД-19 цар тахлын ТББ-уудад үзүүлж буй нөлөө

- Байгууллагын үйл ажиллагаанд КОВИД-19 цар тахал хэрхэн нөлөөлсөн талаар тодруулахад нийт оролцогчдын 50 хувь нь сөргөөр нөлөөлсөн гэж үзсэн бол 15 хувь нь нөлөөлөөгүй, 14.5 хувь нь шинэ боломж бий болгосон, 21.0 хувь зэрэг болон сөргийн аль алинаар нь нөлөөлсөн гэж хариулсан байна.
- Сөргөөр нөлөөлсөн байгууллагууд хэрэгжүүлэх ёстой байсан төлөвлөгөөт үйл ажиллагаанууд тодорхойгүй шалтгаанаар хойшилсон тухай түлхүү дурдсан бол шинэ боломж бий болгосон гэж үзсэн цөөн байгууллагуудын хувьд онлайнаар мэдээлэл авах зайнаас ажиллах талаар шинэ туршлага мэдлэгтэй болсон, дотоод үйл ажиллагаагаа цэгцлэх хянах боломж бий болсон, гишүүнчлэлээ нэмэх боломж бий болгосон, цахим орчинд контент бэлтгэх цацах зэрэг шинэ боломжуудыг олгосон гэжээ.
- Нөхцөл байдалтай холбоотой бэрхшээл саадыг даван туулахад байгууллагад санхүүгийн дэмжлэг, байгууллагын үйл ажиллагааны менежментийн зөвлөгөө, шинэ ур чадварыг сурах, цахим орчинд ажиллах ур чадвараа нэмэгдүүлэх, бусад байгууллагуудаас туршлага судлах зэрэг хариултуудыг дийлэнх байгууллагууд дурдаж байв.

4.2 ЗӨВЛӨМЖ

Төслийн үндсэн чиглэл 1: ТББ-уудын чадавхын хувьд

- Төсөлд хамрагдах сонирхолтой байгаа байгууллагуудад чадавхын хувьд гишүүд, ажилчид, удирдлагатай, үйл ажиллагаа явуулах байрны асуудлыг ихэнх нь шийдвэрлэсэн, менежментийн үндсэн баримт бичгүүдийг боловсруулсан зэрэг байгууллагын үндсэн институтчилэл бүрдсэн хэдий ч цаашид үйл ажиллагааг үр дүнтэй явуулахын тулд одоогийн үйл ажиллагааг бат бэх болгох, байгууллагын менежментийн зөвлөгөө өгөх, боловсруулж буй бичиг баримтууд, түүнийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадвар, сургалт, зөвлөгөө хосолсон чадавхжуулах үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Судалгаанд оролцогч байгууллагууд санхүүгийн бэрхшээл, санхүүгийн дэмжлэг зэрэг санхүүгийн болон материаллаг дэмжлэг байгаа талаар нэлээдгүй санал сэтгэгдлүүд тусгагдаж, тулгамддаг бэрхшээлээ санхүүгийн бэрхшээл хэмээн тодорхойлж байгаа нь ИНБ-уудад санхүүгийн шууд тусламж үзүүлэхээс илүүтэй, төсөв, санхүүгээ зөв удирдах зохицуулах, санхүүжилт босгох, төсвийн санхүүжилтийг шийдвэрлэх арга замууд, хөрөнгө оруулалт татах тал дээр сургалт зөвлөгөө өгөх хэрэгцээтэй байгааг харуулж байна.
- Мөн түүнчлэн иргэний нийгмийн байгууллагуудад төрийн байгууллагын зүгээс дэмжлэг, хамтын ажиллагаа сул байдаг нь бэрхшээлтэй байдаг талаар дийлэнх байгууллагуудын санал гарсан нь иргэний нийгмийн байгууллагуудад холбогдох төрийн байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах, хуулиар зохицуулагдсан боломж, эрхээ хэрхэн ашиглах талаар ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэн чадавхжуулах хэрэгцээтэй байгаа нь ажиглагдаж байна.

Төслийн үндсэн чиглэл 2: ТББ-уудын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хувьд

- Судалгаанд хамрагдсан байгууллагуудын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд нь өргөн хүрээнд биш, сургалт, форум төдийгөөр хязгаарлагддаг, мөн байгууллага хоорондын хамтын ажиллагаа сул байгаатай холбоотойгоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн үйл ажиллагаануудын үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, зохион байгуулдаг сургалтуудыг зөвхөн танхимын сургалт төдийгөөр хийгээд орхих биш, хэрхэн илүү бодит үр дүнтэй байдлаар зохион байгуулах тал дээр мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- Мөн байгууллагуудын хувьд зохион байгуулж байсан үйл ажиллагаа нь хязгаарлагдмал байгаатай холбоотойгоор бусад байгууллагуудаас туршлага судлуулах, олон улсын амжилттай туршлагаас хуваалцах зэргээр үйл ажиллагаа, төслийн цар хүрээг тэлэх боломжийг нэмэгдүүлэх хэрэгцээтэй байна. Зарим ТББ-ууд байгуулагдаад олон жил болсон, үйл ажиллагаа тогтвортой болсон, бусад байгууллагууддаа зөвлөх, туршлага хуваалцах чадавхтай байгааг харгалзан тэдгээр байгууллагуудын туршлагыг чадавх сул байгууллагуудад хуваалцах, сургалт оруулах, хэрхэн санхүүжилт, төсөл босгосон талаар сайн туршлагыг нэвтрүүлэх боломжтой байна.

- Судалгаанд оролцогчдын хувьд төрөөс олгосон хөдөлмөр, бизнес эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн боломж, хүүгүй зээл, орон нутгийн хөгжлийн сан, бичил зээл гэх мэт мэдээлэл, залуучуудад олгогдсон боломжийн талаарх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ойлголтыг дээшлүүлэх хэрэгцээтэй байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагын мэдээллийг нээлттэй, ил тод болгох тал дээр тус төсөл анхаарч ажиллах, холбогдох төрийн байгууллагатай хамтарч ажиллах шаардлагатай байна.

Төслийн үндсэн чиглэл 3: ТББ-уудын иргэний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээрх үйл ажиллагааны хувьд

- **Иргэний оролцоо**–г төслийн хүрээнд энгийн, ойлгомжтой байдлаар тодорхойлж, төсөлд оролцогчдод нэгдсэн, зөв ойлголтыг өгөх.
- Судалгаанд оролцогчдын иргэний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр явуулдаг үйл ажиллагаанууд нь уриалга, цуглаан, албан бичиг төдийгөөр хязгаарлагдаж байгаагаас харахад иргэний бодитой оролцоог нэмэгдүүлэх талаар чадавх, ойлголтыг нэмэгдүүлэх, иргэний нийгмийн байгууллагууд болон залуу хүн нийгмийн сайн сайхан, өөрийн өдөр тутмын амьдралын чанарыг сайжруулахад хэрхэн оролцох, нөлөөлөх боломжтой талаар, иргэний оролцооны тухай ойлголтыг нэмэгдүүлэх.
- Мөн судалгаанд хамрагдагсад залуучуудын чиглэлээр хэрэгжиж буй албан ёсны бодлого, хууль тогтоомжуудыг талаас илүү хувь нь мэдэхгүй гэж хариулсан байгаагаас иргэний оролцооны чиглэлээр хэрхэн оролцох, төрөөс хэрхэн дэмжигдсэн байгаа зэрэг хууль, эрх зүйн орчны мэдлэгийг олгох нь чухал байна.

